



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 564

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 55,000,000.00 (тавин таван сая) төгрөгийн балансын үнэ, 34,222,222.16 (гучин дөрвөн сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М.Даваабат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Онцгойжин  
Б.ГАНБАТ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

З.Гаваа

Б.ГАВАА

0002549

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 12 дугаар сарын 5.6.9-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөрийн  
аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд балансаас  
балансад шилжүүлэх автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хууримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Teana, 79-01 УНҮ, арал № 1N4AL3AP0EC124368	2013/ 2014	55,000,000.00	34,222,222.16	20,777,777.84
	Нийт дүн		55,000,000.00	34,222,222.16	20,777,777.84